

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЙМАГ, СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРЫН ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ХУУЛИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ ҮР ДҮНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ЗААГ-2025/21-12-ШТА-НА

Улиастай хот
2025 он



Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn

Аудитын менежер Х.Болдбаатар
Утас: 7046-3783, Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Заяа
Утас: 90088028, Цахим хаяг: zayaq@audit.gov.mn

Аудитор Б.Мөнхнасан
Утас: 90066888, Цахим хаяг: munkhnasanb@audit.gov.mn

Аудитор Г.Нармандах
Утас: 99031794, Цахим хаяг: narmandakhg@audit.gov.mn

АГУУЛГА

Хүснэгтийн товъёг.....	1
Товчилсон үгийн тайлбар.....	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх.....	3
А. ОРОН НУТАГТ ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.	
А.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5-12 дугаар зүйлийг орон нутагт бүрэн хэрэгжүүлээгүй байна.....	4-7
А.2. Орон нутагт Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.....	8-10
Б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬД ЗААСАН ЖУРМЫГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.	
Б.1. Орон нутгийн удирдлагууд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4, 13.3, 13.4, 13.5 дахь заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.....	10-13
Б.2. Орон нутагт цахим худалдан авалт шаардлагын хэмжээнд хүрч хэрэгжээгүй байна.....	13-14
В. АЙМАГ, СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРЫН ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ ҮР ДҮНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА.	
В.1. Төрийн аудитын байгууллага хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.....	14-15
В.2. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал зардлын хэмнэлт нь төсвийг өмнөх оноос нэмэгдүүлэн баталсантай холбоотойгоор үүссэн байна.....	15-19
В.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт сайжирч байна.....	19
ДҮГНЭЛТ:.....	20-21
ЗӨВЛӨМЖ:.....	22-23
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН НЭГТГЭСЭН АУДИТЫН ТАЙЛАНД ТУСГУУЛАХ САНАЛ.....	24
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	25
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	26

Хүснэгтийн товъёг

Хүснэгт 1. Хуулийн 6 дугаар зүйл 6.5
Хүснэгт 2. Хуулийн 6 дугаар зүйл 6.4
Хүснэгт 3. Хуулийн 11 дугаар зүйл 11.1
Хүснэгт 4. Хуулийн 12 дугаар зүйл 12.1.1
Хүснэгт 5. Хуулийн 15 дугаар зүйл 15.1
Хүснэгт 6. Хуулийн 13 дугаар зүйл
Хүснэгт 7. Аудитаар илэрсэн зөрчлүүд
Хүснэгт 8. ОНТ-ийн зөрчил
Хүснэгт 9. Төсвийн гүйцэтгэл
Хүснэгт 10. Хуулийн 20 дугаар зүйл 20.5

Товчилсон үгийн тайлбар

МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
УИХ	Улсын Их Хурал
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТББ	Төрийн бус байгууллага
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ОНТ	Орон нутгийн төсөв
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЭХЗЗ	Эрчим хүчний зохицуулах зөвлөл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.
Аудитын зорилт	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд, Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/108 дугаар тушаалыг тус тус үндэслэн гүйцэтгэлээ. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийсэн. Үүнд: • Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан уу? • Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмыг хэрэгжүүлж ажилласан уу? • Засгийн газар болон төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байсан уу?
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023, 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, орон нутагт төрийн үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллагууд, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн 2022-2024 оны санхүүгийн тайлан, баримт, мэдээллийг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100-400, 4000, 4001, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын зарчим, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйл цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашигласан.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, аудитын менежер Х.Болдбаатар нар хянан удирдаж, ахлах аудитор Г.Заяа, аудитор Б.Мөнхнасан, аудитор Г.Нармандах нар 2025 оны 03 дугаар сарын 24-өөс эхлэн 2025 оны 05 дугаар сарын 12-ны хугацаанд хийж гүйцэтгэлээ.

БҮЛЭГ А. ОРОН НУТАГТ ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.**А.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5-12 дугаар зүйлийг орон нутагт бүрэн хэрэгжүүлээгүй байна.**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалтын хэрэгжилтийг шалгахад 2022 онд аймгийн Засаг дарга 2 орлогч даргатай ажиллан 2.5 сая төгрөгийн цалин олгосон бөгөөд 2023-2024 онд тус зөрчил арилсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтын хэрэгжилтийг төсвийн шууд захирагчийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар шалган 11.3 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн Аймгийн ЗДТГ-т албан шаардлага хүргүүлсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд 2023 онд аймгийн Орон нутгийн өмчийн газар нь зөвхөн орон нутгийн төсөвт 28 байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглаж байсан автомашиныг лацдан битүүмжилж 6 автомашиныг нээлттэй дуудлага худалдаагаар худалдан борлуулж, төсөвт 31.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Гэвч Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023-2024 онд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор нэмж автомашиныг лацдаж битүүмжлээгүй, эхний лацадсан автомашинуудын хяналт тавиагүй байна. Энэ нь орон нутагт хураагдсан авто тээврийн хэрэгслийг нэгтгэсэн парк байгуулагдаагүйтэй, тухайн парк нь 23 сумдад нийтлэг үйлчилнэ гэвэл ирэх, буцах шатахууны зардал өндөр гарахаар байгаатай холбоотой байна. Нөгөө талаар автомашин ашиглахыг хориглосон байгууллагууд дуудлагаар автомашины үйлчилгээ авах төрийн болон орон нутгийн өмчит авто тээврийн байгууллага байхгүйгээс хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй өндөр үнээр түрээсийн гэрээ байгуулдаг, албан томилолтоор хөдөө орон нутагт ажиллах үеийн аюулгүй байдалд эрсдэл учрах нөхцөл байдал үүсдэг, сумдын сургуулийг хэмнэлтийн хуулиар автомашин ашиглахыг хориглосон байхад ихэнх уралдаан, тэмцээн, олимпиад, элсэлтийн шалгалтыг Улиастай суманд зохион байгуулж байгаа нь хүндрэл бэрхшээлийг үүсгэдэг байна. Иймд хуулийн 6.3 дахь заалтыг хүчингүй болгуулах саналтай байна.

Аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дээрх заалтын хэрэгжилтийг 2024 оны байдлаар шалгахад тээврийн хэрэгсэл ашиглахыг хориглосон 28 байгууллагад 33 автомашин бүртгэлтэй байна. Аймгийн Нийгмийн даатгалын газраас бусад байгууллага жолоочийн орон тоог цомхотгох, өөр албан тушаалд сэлгүүлэн ажиллуулах шийдвэрийн аль нэгийг гаргаагүй доорх байгууллагууд байна.

Хүснэгт 1. Хуулийн 6 дугаар зүйл 6.5

№	Нэр	Тоо	Автомашины марк
1	Асгат ЕБС	2	Суудлын
2	Баянтэс сумын ЕБС	1	Суудлын
3	Дөрвөлжин ЕБС	1	Суудлын
4	Завханмандал ЕБС	1	Суудлын
5	Нөмрөг соёлын төв	1	Суудлын
6	Идэр ЕБС	1	Суудлын
7	Их-Уул ЕБС	1	Суудлын
8	Их-Уул соёлын төв	1	Суудлын
9	Отгон ЕБС	1	Суудлын

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн			
10	Сонгино ЕБС	2	Суудлын, Автобус
11	Тэс ЕБС	2	Суудлын
12	Тосонцэнгэл 1-р сургууль	1	Суудлын
13	Тосонцэнгэл 2-р сургууль	1	Суудлын
14	Тосонцэнгэл соёлын төв	1	Суудлын
15	Тэлмэн ЕБС	1	Суудлын
16	Түдэвтэй ЕБС	2	Суудлын, Автобус
17	Улиастай сум 4-р сургууль	1	Суудлын
18	Ургамал	1	Автобус
19	Цагаанхайрхан ЕБС	1	Суудлын
20	Цагаанчулуут ЕБС	1	Суудлын
21	Цэцэн-Уул ЕБС	1	Автобус
22	Шилүүстэй ЕБС	2	Суудлын
23	Эрдэнэхайрхан ЕБС	1	Суудлын
24	Яруу ЕБС	1	Суудлын
25	Номын сан	1	Суудлын
26	Мүзей	1	Суудлын
27	Хөгжимт жүжгийн театр	1	Автобус
28	Нийгмийн даатгалын хэлтэс	1	Суудлын
	Дүн	33	

Эх сурвалж: Аймгийн ОНӨГазар, Авто тээврийн төв.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дахь заалтын хэрэгжилтийг шалгахад 126 төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй зөрчил илэрлээ.

Хүснэгт 2. Хуулийн 6 дугаар зүйл 6.4

№	Нэр	Тод цэнхэр дугаар аваагүй тээврийн хэрэгслийн тоо
1	Нутгийн удирдлагын салбар байгууллагууд	61
2	Эрүүл мэндийн салбар байгууллагууд	14
3	Боловсролын салбар байгууллагууд	15
4	Соёлын салбар байгууллагууд	6
5	Завхан АЗЗА, Отгонтэнгэр нисэх буудал ТБОНӨААТҮГ/, Амь-Ус ОНӨҮГ	11
6	Улиастай, Тосонцэнгэл хот тохижилт үйлчилгээний алба	17
7	Аймгийн Байгаль орчны газар	2
	Дүн	126

Эх сурвалж: Аймгийн ОНӨГазар, Авто тээврийн төв.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтын хэрэгжилтийг шалгахад зөрчил илрээгүй.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтын хэрэгжилтийг төсвийн шууд захирагчийн 2022-2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар шалган 20.2 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн, аудитын шийдвэрийг гарган шалгадагч байгууллагад хүргүүлж биелэлтийг тооцсон байна.

- ✓ 2022 онд Түдэвтэй сумын Ойн анги, Ерөнхий боловсролын сургууль, “Амь-Ус” ХХК, “Завхан АЗЗА” ТӨХК, Тосонцэнгэл сумын МСҮТ зэрэг байгууллагууд төсвийн 5.4 сая төгрөгийн хөрөнгөөр хувцас бэлтгэсэн.
- ✓ 2023 онд Алдархаан, Шилүүстэй, Сонгино, Цэцэн-Уул, Ургамал, Түдэвтэй, Их-Уул, Сантмаргаз, Дөрвөлжин зэрэг сумдын соёлын төвүүд, Алдархаан, Улиастай, Ургамал сумдын ЗДТГ-ууд төсвийн 10.4 сая төгрөгийн хөрөнгөөр хувцас бэлтгэсэн.
- ✓ 2024 онд Яруу, Идэр сумдын ЗДТГ төсвийн 4.4 сая төгрөгийн хөрөнгөөр хувцас бэлтгэсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтын хэрэгжилтийг шалгахад зөрчил илрээгүй.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг аймгийн ИТХ нь хэрэгжүүлээгүй байгаа тул аудитаар зөрчлийг арилгах зөвлөмж өглөө. Аймагт үйл ажиллагаа явуулдаг 6 орон нутгийн өмчит хуулийн этгээд нь 2022-2024 онуудад ТУЗ-ын тогтоолоор гүйцэтгэх захирал, бусад албан хаагчдын цалингийн сангийн төсвийг баталсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтын хэрэгжилтийг энэ аудитаар шалган тэтгэвэрт гарсан 15 албан хаагчид 6.2 сая төгрөгийн тэтгэмж давхардуулан олгосон зөрчлийг илрүүллээ.

Хүснэгт 3. Хуулийн 11 дугаар зүйл 11.1
/сая төгрөгөөр

Зөрчилд авсан арга хэмжээ.	2022 он		2023 он		2024 он		Нийт дүн	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар	11	304.1	1	31.3	1	0.5	13	335.9
	11	304.1	1	31.3	1	0.5	13	335.9
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт аудитаар илэрсэн алдаа зөрчил	6	1.6	4	1.7	5	2.9	15	6.2
Нийт	6	1.6	4	1.7	5	2.9	15	6.2

Эх сурвалж: Fas program шийдвэрийн дэлгэрэнгүй бүртгэл, тушаалууд

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн хэрэгжилтийг төсвийн шууд захирагчийн 2022-2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар шалган 165.7 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн, аудитын шийдвэрийг гарган шалгадагч байгууллагад хүргүүлж биелэлтийг тооцсон байна.

Хүснэгт 4. Хуулийн 12 дугаар зүйл 12.1.1
/сая төгрөгөөр/

№	Он	Зөрчлийн товч утга	Зөрчлийн дүн	Авсан арга хэмжээ
1	2022	Аймгийн Засаг даргын тамгын газар Засаг даргын ажлын тайлангаар сонин хэвлэж тараасан	18.4	Албан шаардлага
2		Улиастай сумын ИТХ-ын зөвлөлийн гишүүдэд гар утасны зардал гаргасан	0.5	
3		Улиастай сумын ИТХ-ын ажлын албаны ажлын	4.2	

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн				
		тайлангаар сонин хэвлэж тараасан		
4		Тэс сумын ИТХ Алба хаагчдын гар утасны төлбөр төлсөн	0.2	
5		Их-Уулс ЗДТГ Байгаль хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөр, бараа үйлчилгээний зардлаас сонин хэвлүүлсэн.	2.5	
Дүн			25.9	
1	2023	Улиастай сумын засаг дарга Засаг даргын Тамгын газрын ажилчдыг БНХАУ-ын Жинин, Хөх хот, бусад хотууд руу аялуулсан зориулалт бус, үрэлгэн зардал гаргасан	20.0	Албан шаардлага
2		Орон нутгийн хөгжлийн сангаас ахмадын баяр, ахмадын шинэ жилийн арга хэмжээ, номын хэвлэл, телевизийн гэрээний төлбөр, төрийн албан хаагчийн сургалтын төлбөр гаргаж, зориулалт бус зарцуулсанд албан шаардлага хүргүүлсэн.	19.4	
Дүн			39.4	
1	2024	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас контент, аймгийн 100 жилийн ойн байр наадмыг ТВ5, ТВ9 телевизээр шууд дамжуулах зэрэг зориулалт бус арга хэмжээнд зарцуулсан.	70.0	Албан шаардлага
2		Газрын харилцаа үүсэж хөгжсөний 70 жилийн ойн арга хэмжээний хүрээнд ойн хэвлэл захиалах, сайн үйлсийн аянд оролцох, ахмадуудыг хүлээн авахад зориулж барилгын захиалагчийн хяналтын зардлаас гаргасан	8.9	Зөвлөмж
3		Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас эрх шилжсэн 20.0 сая төгрөгийн дэмжлэгийг яруу сумын 100 жилийн ойн арга хэмжээний медаль, үнэмлэх, ном хэвлэлийн зардалд зориулалт бус зарцуулсан.	18.5	Албан шаардлага
4		Тосонцэнгэл сумын ЗДТГ сумын 100 жилийн ойд зориулан хэвлэлийн зардал гаргасан байна.	3.0	
Дүн			100.4	

Эх сурвалж: Fas program шийдвэрийн дэлгэрэнгүй бүртгэл.

А.2. Орон нутагт Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Өмнөх аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалттай холбоотой 707.8 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн аудитын шийдвэрийг шалгагдагч байгуулагад хүргүүлж биелэлтийг тооцсон байна.

Хүснэгт 5. Хуулийн 15 дугаар зүйл 15.1
/сая төгрөгөөр/

Аудитын нэр	Илэрсэн зөрчлийн товч утга	Мөнгөн дүн
15.1.2. "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох";		
Төсвийн шууд захирагчийн 2022-2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудит	2022 онд Баянтэс, Цагаанчулуут сумын ЗДТГ-ын дарга, 2023 онд Тэс сумын ЗДТГ-ын дарга, 2024 онд Баянтэс, Баянхайрхан сумдын соёлын төвийн эрхлэгч нь батлагдсан бүтэц орон	40.2

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн		
	тооноос тус бүр 1 орон тоог нэмэгдүүлсэн	
	2023 онд аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын дарга батлагдсан бүтэц орон тооноос 5 орон тоог нэмэгдүүлсэн	41.9
	Аймгийн Эрүүл мэндийн газрын бүтэц орон тоог аймгийн Засаг нь 2023 оны А/384 тоот захирамжаар батлахдаа Нийгмийн эрүүл мэндийн төвийн хэлтэст чиг үүрэг нь давхардсан 2 албаны даргын орон тоог шинээр баталснаас 2023 оны 11 дүгээр сард “захиргаа урьдчилан сэргийлэх албаны дарга” гэсэн орон тоонд мэргэжлийн шаардлага хангаагүй ажилтныг томилон ажиллуулсан зөрчлийг арилгах зөвлөмжийг ЭМГ-т хүргүүлсэн.	31.6
“Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудит	Аймгийн Эрүүл мэндийн газар нь “захиргаа урьдчилан сэргийлэх албаны дарга” гэсэн орон тоог цомхотгох гэсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байсан тул “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар аймгийн Засаг даргад албан шаардлага хүргүүлсэн.	
15.1.3.“хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”;		
Төсвийн шууд захирагчийн 2022-2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудит	2022-2024 онд 24 төсөвт байгууллагын удирдлага хууль, журам зөрчин ажилтнуудад тэтгэмж олгосон	212.9
15.1.4. байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх;		
Төсвийн шууд захирагчийн 2022-2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудит	2023 онд Аймгийн ОНХС, 2024 онд Улиастай, Идэр сумын ЗДТГ контент бэлтгэсэн	37.0
15.1.6.нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;		
Төсвийн шууд захирагчийн 2022-2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудит	2022 онд 2 байгууллага бараа материал их хэмжээгээр нөөцөлсөн.	8.5
15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;		
Төсвийн шууд захирагчийн 2022-2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудит	2023-2024 онд 23 байгууллага төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан.	273.7
15.1.7.байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах.		
Төсвийн шууд захирагчийн 2022-2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудит	2023-2024 онд 4 байгууллага төсвийн хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авсан.	3.0
15.1.8.байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах		

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн			
Төсвийн захирагчийн оны санхүүгийн хийсэн аудит	шууд 2022-2024 оны санхүүгийн тайланд	2023-2024 онд 13 байгууллага уралдаан тэмцээний зардлыг төсвөөс санхүүжүүлсэн	57.0
Дүн			707.8

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн хэрэгжилтийг энэ аудитаар эрүүл мэнд, боловсрол, соёлын салбар байгууллагуудад түүвэрчлэн шалгаж 352.7 сая төгрөгийн зөрчил илрүүлэн холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж хүргүүлээ.

- Ургамал сумын Засаг дарга нь тус сумын Эрүүл мэндийн төвийн орон тоог 2024 онд батлаагүй бөгөөд 2025 онд 2 их эмчээр нэмэгдүүлсэн нь Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын 2015 оны 498/315 дугаартай хамтарсан тушаалаар батлагдсан “Сум тосгоны эрүүл мэндийн төвийн орон тооны норматив”-ыг зөрчсөн байна. Тус сумын эрүүл мэндийн төвийн багийн эмч нарын дутагдлыг их эмч нар нөхөж байгаа ч чиг үүргийн давхардлаас шалтгаалан 4.8 сая төгрөгийн цалин олгосон.
- Аймгийн ИТХ, Байгаль орчны газар, Орон нутгийн өмчийн газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар, Эрүүл мэндийн газар, Уламжлалт анагаах ухааны газар, Тосонцэнгэл сумын ИТХ, Их-Уул, Нөмрөг, Тэс сумдын соёлын төв зэрэг 10 байгууллагын удирдлага нь ажилтнуудад хууль журамд тусгагдаагүй 11.2 сая төгрөгийн тэтгэмж олгосон. Төрийн албан хаагчид олгох тусламж, дэмжлэг, тэтгэмжийг Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1-д тусган, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр”-ийг журамласан боловч төрийн албан хаагч шинээр гэр бүл болох, гэр бүлийн хүн нь нас барах, шинээр хүүхэдтэй болох зэрэгт үзүүлэх тусламж дэмжлэг нь журамлагдаагүй, зөвхөн байгууллагын дотоод журмаар зохицуулагдаж байгаад анхаарч, холбогдох байгууллагад нь уламжлах шаардлагатай байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д “байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэхийг хориглоно” гэж заасныг хүчингүй болгуулах саналтай байна. Учир нь төрийн байгууллагууд хийсэн ажлын тайлан, үр дүн, үйл ажиллагааны цар хүрээгээ цахим сүлжээ ашиглан контент, нэвтрүүлэг хэлбэрээр түгээхгүй байх нь төрийн үйлчилгээний хүртээмж, үр дүнд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.
- 2024 онд Баянхайрхан, Улиастай, Ургамал, Тэс сумдын ЗДТГ, аймгийн Байгаль орчны газар зэрэг нь нэмэлт санхүүжилтийн орлогоос 26.5 сая төгрөгийн шатахуун нөөцөлсөн, Эрүүл мэндийн салбарын 6 байгууллагын эм эмнэлгийн хэрэгслийн үлдэгдлээс 92.1 сая төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийн хугацаа дууссан, 1 байгууллага 12.1 сая төгрөгийн эм нөөцөлсөн, аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмийн үлдэгдэл E-Health программын үлдэгдлээс 127.9 сая төгрөгөөр зөрсөн, боловсролын салбарын 12 байгууллагын 16.5 сая төгрөгийн хүнсний материалын үлдэгдлийн хугацаа дууссан, 9 байгууллага 51.2 сая төгрөгийн хүнсний материалыг шаардлагатай хэмжээнээс илүү нөөцөлсөн, 3 байгууллага хүнсний материалыг зах зээлийн үнээс 10.4 сая төгрөгөөр илүү бэлтгэсэн.

- Аймагт үйл ажиллагаагаа явуулдаг 7 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтыг хэрэгжүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулаагүй байна.

БҮЛЭГ Б: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬД ЗААСАН ЖУРМЫГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

Б.1. Орон нутгийн удирдлагууд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4, 13.3, 13.4, 13.5 дахь заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Төсвийн шууд захирагчийн 2022-2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит болон “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн хэрэгжилтийг шалган 12,298.6 сая төгрөгийн зөрчил илрүүлэн аудитын шийдвэрийг шалгагдагч байгууллагуудад хүргүүлсэн байна

Хүснэгт 6. Хуулийн 13 дугаар зүйл
/сая төгрөгөөр/

Хуулийн заалт	Аудитын нэр	Мөнгөн дүн	Аудитын шийдвэр
13.3.Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно:			
13.3.1.хөшөө, дурсгал, орон нутгийн утгах, үдэх хаалга барьж байгуулах;	Төсвийн шууд захирагчийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар	320.0	Албан шаардлага
13.3.3.техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.	“Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”	1,975.4	Зөвлөмж
13.4.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно:			
13.4.1.орон нутгийн нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, хаягжуулалд, гэрэлтүүлэг, тохижилт;	“Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”	1,503.5	ҮАГ-т санал хүргүүлсэн
13.5.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.	“Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”	6,674.3	Зөвлөмж
	Төсвийн шууд захирагчийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар	1,808.0	Албан шаардлага, Зөвлөмж
	Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар	17.4	Албан шаардлага
Дүн		12,298.6	

Энэ аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.6, 13.7 дахь заалтуудыг шалгахад алдаа зөрчил илрээгүй.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс 2023-2024 онуудад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.4 дэх заалтыг хэрэгжүүлсэн эсэхийг шалгахад 2023 онд 1 хуулийн этгээдтэй 69.8 сая төгрөгийн, 2024 онд 3 хуулийн этгээдтэй 319.3 сая төгрөгийн гэрээ байгуулсан зөрчил илэрлээ.

Хүснэгт 7. Аудитаар илэрсэн зөрчлүүд
/сая төгрөгөөр/

Төсөл арга хэмжээний нэр	Гэрээ байгуулсан захиалагч	Гэрээний дүн
2023 онд		
Завхан аймгийн Отгон сумын Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны засварын ажил	Отгон сумын Засаг дарга	69.6
2024 онд		
Төвлөрсөн халаалт цэвэр усны шугамд ААНБ, айл өрхүүдийг холбох салбар шугамын ажлыг дэм дараалалтай хийнэ.	Дөрвөлжин сумын Засаг дарга	198.0
Сумын төвийн гэрлийн шонгийн 0.4-ийн цахилгааны шугамын шинэчлэл хийнэ.	Дөрвөлжин сумын Засаг дарга	79.5
Бэлчээр ашиглалт, усан хангамжийг сайжруулах зорилгоор Баянтэс суманд инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах	Баянтэс сумын Засаг дарга	41.8
Дүн		388.9

Аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь 2023 онд 46 төсөл арга хэмжээнээс 539.9 сая төгрөгийн, 2024 онд 78 төсөл арга хэмжээнээс 2,807.7 сая төгрөгийн тендерийн хэмнэлтийг бий болгож, уг хэмнэлтийг зарцуулалгүй Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтыг хэрэгжүүлсэн байна.

Аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд 12,742.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 92 төсөл арга хэмжээг орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр тусгажээ. Энэ 92 төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь заалтыг мөрдөн хэрэгжүүлсэн эсэхийг шалгахад 3,235.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 20 төсөл арга хэмжээ нь ТЭЗҮ, зураг төсөвгүйгээр батлагдсан, 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээ нь орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, хөрөнгө оруулалтын бус шинж чанартай гэсэн зөрчлүүд илэрлээ.

Хүснэгт 8. ОНТ-ийн зөрчил
/сая төгрөгөөр/

№	Төсөл арга хэмжээний нэр	Мөнгөн дүн	Зөрчлийн утга
1	Баянтэс сумын төвд нийтийн спортын талбай байгуулах	500.0	Батлагдсан зураг төсөвгүй төсөл арга хэмжээ
2	Ургамал сумын ерөнхий боловсролын сургуулийг засварлах	400.0	
3	Шилүүстэй суманд нийтийн биеийн тамирын талбай байгуулах	370.0	

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн			
4	Улиастай сумын долоо дугаар цэцэрлэгийн урлаг заалны барилгыг өргөтгөж засварлах	350.0	
5	Цагаанчулуут сумын соёлын төвийн барилгад их засвар хийх	260.0	
6	Улиастай сумын Чигэстэй, Жинст багийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх	200.0	
7	Тэлмэн сумын соёлын төвийн барилгад их засвар хийх	150.0	
8	Завханмандал сумын Хүнгийн голын ногоон хэрмийн бөөрний сувиллыг засварлах	150.0	
9	Биеийн тамир, спортын газрын , спорт заалны шалыг шинэчилж засварлах	128.0	
10	Сантмаргаз сумын ЭМТ-ийн хайсыг шинэчилж, эмч нарын байрыг засварлах	100.0	
11	Улаан хаалгын ахмадын сувиллын байрыг засварлах	80.0	
12	Тэс сумын сургуулийн 320 хүүхдийн хичээлийн байрын дулаан алдагдлыг бууруулах	80.0	
13	Тэлмэн сумын хүүхдийн цэцэрлэгт засвар хийх	80.0	
14	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын заалыг засварлах	79.8	
15	Цагаанхайрхан сумын нийтийн спортын талбайг засаж, тохижуулах	70.0	
16	Үндэсний сурын талбайг нэмж тохижуулах	67.4	
17	Тосонцэнгэл сумын Рашаант баг хүртэлх ЦДАШ-д засвар хийх	50.0	
18	Завханмандал сумын төвийн гэр хорооллын дөрвөн гудамжийг гэрэлтүүлэгтэй болгох	50.0	
19	Улиастай сумын сургуулиудын ойр орчмын авто зам дээр ЛЕД гэрэлтүүлэгтэй явган хүний гарц хийх	37.2	
20	Холбооны 27-р байрны баруун талд авто зогсоол хийх	33.5	
21	Тосонцэнгэл суманд ахмадын чуулган зохион байгуулах	30.0	
	Дүн	3,265.9	Улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, хөрөнгө оруулалтын бус төсөл арга хэмжээ

Дээрх зөрчлүүд нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.2, 13.3.3 дахь заалтуудыг зөрчсөн тул 3,265.9 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох албан шаардлагыг аймгийн ИТХ-д болон Засаг даргад өгөхөөр шийдвэрлэлээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дахь заалтыг “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт” сэдэвт аудитаар шалгасан тул уг аудитад хамруулаагүй болно.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь заалтын хэрэгжилтийг шалгахад аймгийн ОНХС-ын хөрөнгөөр 2023 онд 8,210.3 сая төгрөгийн 107 төсөл арга хэмжээ, 2024 онд 5,978.3 сая төгрөгийн 40 төсөл арга хэмжээг төлөвлөж, батлахдаа орон нутгийн иргэдээс санал авч, эрэмбэлээгүй зөрчил илэрлээ.

Сумын ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг сумдын ИТХ-аас батлахдаа орон нутгийн иргэдээс санал авч, эрэмбэлсэн эсэхийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн Удирдлагын мэдээллийн системээс түүвэрлэн шалгахад сумдын байгуулагдсан ажлын хэсэг иргэдээс ирсэн саналыг эрэмбэлсэн байна.

Б.2. Орон нутагт цахим худалдан авалт шаардлагын хэмжээнд хүрч хэрэгжээгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалтыг сумдын ЗДТГ, сургууль, хүүхдийн цэцэрлэгүүдээс түүвэрлэн шалгахад хүсэлт өгсөн байгууллага байхгүй байна.


2023, 2024 онуудад цахим дэлгүүрт байршсан бараа бүтээгдэхүүнүүдээс 52 байгууллага давхардсан тоогоор 955 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг нийт 6,627.7 сая төгрөгөөр худалдан авсан байна. Эдгээр худалдан авалтын дийлэнх хувийг Эрүүл мэндийн салбар болон Боловсролын салбараас худалдан авалт хийсэн байна.

Аймагт үйл ажиллагаа явуулдаг 200 байгууллагаас 52 байгууллага буюу 25 хувь нь цахим худалдан авалт хийсэн байгаа нь шаардлагын хэмжээнд хүрээгүй байна. Энэ нь цахим дэлгүүрт байршсан бараа бүтээгдэхүүн зах зээлийн үнээс өндөр үнэтэй, худалдан авагчийн тавьсан шаардлагад нийцэхгүй байгаатай холбоотой байна.

Салбаруудын цахим дэлгүүрээс худалдан авсан бараа үнийн дүн хувиар



Цахим дэлгүүрийн худалдан авалт



БҮЛЭГ В. АЙМАГ, СУМДЫН ЗАСАГ ДАРГЫН ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ ҮР ДҮНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА.

В.1. Төрийн аудитын байгууллага хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Энэ хуулийн хэрэгжилтэд төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллана” гэж заасан.

Төрийн аудитын байгууллага Монгол улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/89 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг баримтлан хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

- 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 332.5 сая төгрөгийн зөрчил илрүүлэн, 43.8 сая төгрөгийн зөрчилд 23 төлбөрийн акт, 265.8 сая төгрөгийн зөрчилд 30 албан шаардлага, 22.8 сая төгрөгийн зөрчилд 8 зөвлөмж өгсөн байна.
- 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 472.5 сая төгрөгийн зөрчил илрүүлэн, 3.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 39.8 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 429.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна.
- 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 227.9 сая төгрөгийн зөрчил илрүүлэн 5.2 сая төгрөгийн төлбөрийн акт, 211.4 сая төгрөгийн зөрчилд 11 албан шаардлага, 11.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна.

В.2. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал зардлын хэмнэлт нь төсвийг өмнөх оноос нэмэгдүүлэн баталсантай холбоотойгоор үүссэн байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2023 онд 67,698.3 сая төгрөгийн тодотгон батлагдсан төсвөөс 6,948.9 сая төгрөгийг зарцуулаагүй 89.7 хувийн гүйцэтгэлтэй, 2024 онд 93,135.8 сая төгрөгийн тодотгон баталсан төсвөөс 8,107.6 сая төгрөгийг зарцуулаагүй 89.7 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Хүснэгт 9. Төсвийн гүйцэтгэл

д/д	Зардлын төрөл	2023 оны Төлөвлөгөө	2023 оны Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	2024 оны Төлөвлөгөө	2024 оны Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
НИЙТ ЗАРДАЛ		67,698.90	60,749.95	6,948.95	93,135.80	85,028.30	8,107.50
УРСГАЛ ЗАРДАЛ		39,616.76	37,422.30	2,194.46	55,975.70	53,421.50	2,554.20
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,805.93	14,381.66	424.27	22,389.80	21,657.10	732.70

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн							
2	Ажил олгогчоос төлөх НДШ	1,853.15	1,808.55	44.60	2,801.50	2,742.70	58.80
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,854.80	11,463.18	391.62	16,150.40	15,221.80	928.60
4	Хангамж бараа материалын зардал	1,097.32	1,029.99	67.33	1,113.10	1,095.30	17.80
5	Норматив зардал	175.74	175.74	0.00	189.4	189.4	0.00
6	Эд хогшил урсгал засварын зардал	712.73	656.23	56.50	932.7	885.8	46.90
7	Томилолт зочны зардал	377.55	355.67	21.88	501.6	497.7	3.90
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,336.25	3,171.81	164.44	4,398.10	4,207.70	190.40
9	Бараа үйлчилгээний бусад зардал	3,917.89	3,479.73	438.16	4,914.10	4,405.40	508.70
10	Гадаад зээлийн хүүгийн төлбөр	568.70		568.70			
11	Хувийн хэвшлийн байгууллагад өгөх татаас	12.95	12.95	0.00	12.7	12.7	0.00
12	Бусад урсгал шилжүүлэг буюу тэтгэмж урамшуулал	903.74	886.79	16.95	2,572.40	2,505.90	66.50
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		25,048.36	21,700.93	3,347.43	34,327.40	30,360.40	3,967.00
Эргэж төлөгдөх зээл		3,033.77	1,626.72	1,407.05	2,832.80	1,246.30	1,586.50

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 2023-2024 онд хөрөнгийн зардлыг 3,347.4-3,967.0 сая төгрөгөөр, эргэж төлөгдөх зээлийн зардлыг 1,407.0-1,586.4 сая төгрөгөөр, урсгал зардлыг 2,198.5-2,554.2 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

Хөрөнгийн зардал: Их засварын болон бусад хөрөнгө оруулалтын зардал нь гүйцэтгэлээр санхүүжсэн, зарим төсөл арга хэмжээ нь тайлант хугацаанд огт хэрэгжээгүй, зарим төсөл арга хэмжээ нь гэрээт хугацаандаа бүрэн дуусаагүй зэргээс шалтгаалан тус зардалд 3,347.4-3,967.0 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсаныг хэмнэлтэд тооцоогүй.

Эргэж төлөгдөх зээлийн зардал: Энэ зардлыг тайлант хугацаанд 1,407.0 - 1,586.4 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авч, төсөл хэрэгжүүлэх шаардлагыг хангасан хоршоо орон нутагт цөөн байдгаас зээл олголт хийгдээгүй холбоотой байна. Аудитаар эргэж төлөгдөх зээлийн зардлын дутуу зарцуулалтыг хэмнэлтэд тооцоогүй болно.

Гадаад зээлийн хүүгийн зардал: 2023 онд 568.7 сая төгрөгөөр төлөхөөр төлөвлөсөн боловч төлөлтийг хийгээгүй, 2024 онд тус зардлыг төлөвлөөгүй нь Өрийн удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д “Эцсийн зээлдэгч нь дамжуулан зээлдүүлэх зээлийн үндсэн, хүүгийн болон бусад төлбөрийг гэрээнд заасны дагуу төлөх үүрэгтэй” гэж заасныг зөрчсөн байна. Гадаад зээлийн хүүгийн зардлын дутуу зарцуулалтыг хэмнэлтэд тооцоогүй болно.

2023 онд урсгал зардлыг 1,625.8 сая төгрөгөөр хэмнэсэн нь цалин, НДШ-ийн зардлын хэмнэлт 28.8 хувиар, бараа үйлчилгээний бусад зардлын хэмнэлт 27.0 хувиар, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын хэмнэлт 24.1 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлын хэмнэлт 10.1 хувиар голлох нөлөөг үзүүлж байна.

2024 онд урсгал зардлыг 2,554.2 сая төгрөгөөр хэмнэсэн нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын хэмнэлт 36.4 хувиар, цалин, НДШ-ийн зардлын хэмнэлт 31.0 хувиар, бараа үйлчилгээний бусад зардлын хэмнэлт 19.9 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн хэмнэлт 7.5 хувиар голлох нөлөөг үзүүлж байна.

Цалингийн зардал: 2023 онд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт 55 байгууллагын 764 орон тоонд 14,805.9 сая төгрөгийн цалингийн зардал төлөвлөж, гүйцэтгэлээр 754 орон тоонд 14,381.7 сая төгрөгийг зарцуулжээ.

2024 онд 786 орон тоонд 22,389.8 сая төгрөгийн цалингийн зардал төлөвлөж, гүйцэтгэлээр 763 орон тоонд 21,657.17 сая төгрөгийг зарцуулснаас харахад тус зардлын хэмнэлтийн ихэнх хувь нь орон тоо дутуу ажилласантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

2024 онд Их-Уул, Нөмрөг сумдын ИТХ, Нөмрөг, Тосонцэнгэл сумдын ЗДТГ нь батлагдсан орон тооноос 4 орон тоо дутуу ажилласны цалингийн хэмнэлтээс 30.3 сая төгрөгийг байгууллагын ажиллагсдын урамшуулал, бусад зардалд зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4-д “төрийн байгууллагын орон тоо, цалин хөлсний төлөвлөлт, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох” гэж заасныг зөрчсөн байна.

Бараа үйлчилгээний бусад зардал: 2023 онд тус зардлыг 3,917.9 сая төгрөгөөр төлөвлөн, 3,479.7 сая төгрөг зарцуулж, гүйцэтгэл нь 88.8 хувьтай байсан бол 2024 онд 4,914.1 сая төгрөгөөр төлөвлөн, 4,405.4 сая төгрөг зарцуулж, гүйцэтгэл нь 89.6 хувьтай байна.

2024 онд тус зардлыг өмнөх оноос 996.2 сая төгрөгөөр буюу 25.4 хувиар нэмэгдүүлэн баталсан нь аймаг, сумдын Засаг даргын нөөц хөрөнгийн төсвийг орон нутгийн давсан орлогоос нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Гэтэл нэмэгдүүлсэн хэмжээнээс 508.7 сая төгрөгийг хэмнэж байгаагаас үзэхэд аймаг, сумдын ЗДТГ-ын удирдлагууд бараа үйлчилгээний зардлыг судалгаа, тооцоонд үндэслэлгүй төлөвлөдөг, нөөц сангийн хөрөнгийг баяр ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ, нутгийн зөвлөлийн золголт зэрэгт үрэлгэн зарцуулдаг зөрчил нийтлэг байна.

Бараа үйлчилгээний бусад зардлын гүйцэтгэлийг санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрчлэн шалгахад 8 байгууллагад 165.4 сая төгрөгийн төсвийн хөрөнгийг үрэлгэн

зарцуулсан зөрчил илэрсэн нь төсвийн шууд захирагч нар Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-д “төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Алдархаан, Дөрвөлжин, Отгон, Сонгино, Тэс, Улиастай сумдын ЗДТГ нь бараа үйлчилгээний зардлаас хүндэтгэлийн арга хэмжээ, баяр ёслол, уралдаан тэмцээнд 85.9 сая төгрөгийг үрэлгэн зарцуулсан зөрчил илэрлээ.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал: 2023 онд 11,854.8 сая төгрөгөөр төлөвлөн, 11,463.2 сая төгрөг зарцуулж, гүйцэтгэл нь 96.7 хувьтай байсан бол 2024 онд 16,150.4 сая төгрөгөөр төлөвлөн, 15,221.8 сая төгрөг зарцуулж, гүйцэтгэл нь 94.3 хувьтай байна.


2024 онд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг өмнөх оноос 4,295.6 сая төгрөгөөр буюу 36.2 хувиар нэмэгдүүлэн баталсан нь аймгийн ЭХЗЗ-өөс халаах эзлэхүүний үнэ тарифыг 2,165.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны төвийн байр ашиглалттай холбоотой 2,130.4 сая төгрөгийн тогтмол зардлыг Сангийн яамны шийдвэрээр орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр болсон зэрэгтэй холбоотой байна. Гэтэл аймгийн Нэгдсэн эмнэлэг, Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны төвийн тогтмол зардлын төсөвлөлтийг аймгийн ЭМГ-аас илүү тооцоолсон, аймгийн нэгдсэн эмнэлгийг буулгасан зэргээс шалтгаалан 441.6 сая төгрөгийн хэмнэлт үүссэн, зарим сургуулийн барилгын халаах эзлэхүүн буруу хэмжигдсэн, зарим сургуулийн барилга актлагдсан, шинээр баригдаж байгаа сургууль, цэцэрлэгийн барилга гэрээт хугацаандаа ашиглалтад ороогүй, зарим сургууль, цэцэрлэгийн нягтлан бодогч нар өрийн мэдээллээ буруу гаргасан зэргээс шалтгаалан 487.0 сая төгрөгийн тогтмол зардал хэмнэгдсэн байна. Аудитын явцад аймгийн ЗДТГ-ын төсвийн мэргэжилтэнтэй ярилцлага хийхэд халаах эзлэхүүний хэмжилт, барилгын данснаас хасалттай холбоотойгоор 164.8 сая төгрөгийн халаалтын зардлын төсвийг 2025 оны орон нутгийн төсвөөс хасаж тооцсон гэсэн тайлбарыг өглөө.

Аудитын илрүүлэлт:

- 2024 онд халаах эзлэхүүний үнэ тарифыг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор халаалтын зардлын гүйцэтгэлийг өмнөх оноос 2,069.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх” гэж заасныг хэрэгжүүлээгүй, дулаан үйлдвэрлэгч компаниудад утаа шүүх шүүлтүүртэй болох, энгийн халаалттай хувийн сууцтай иргэдийг нэгдсэн халаалтад холбох үүргүүдийг хүргүүлээгүй байна. Энэ нь аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвөөс гаргасан 2024 оны агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тооллогын тайланд агаар бохирдуулах суурин эх үүсвэрийн тоо өмнөх оноос 128 нэгжээр нэмэгдсэн, 6,763.5 тн хортой хий агаарт хаягдсан нь өмнөх оноос буураагүй гэснээр нотлогдож байна.
- Улиастай сумын 3, 8 дугаар цэцэрлэгийн, Сантмаргац сумын сургууль, цэцэрлэгийн, Тосонцэнгэл сумын 2 дугаар сургууль, 4 дүгээр цэцэрлэгийн,

Нөмрөг сумын сургуулийн нягтлан бодогч нар өрийн мэдээллийг 104.5 сая төгрөгөөр буруу мэдээлсэн, аймгийн Эрүүл мэндийн газрын төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн 3 эмнэлгийн тогтмол зардлын төсвийг 289.7 сая төгрөгөөр илүү тооцоолсон байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал:



2024 онд тус зардлыг өмнөх оноос 1,061.8 сая төгрөгөөр буюу 31.8 хувиар нэмэгдүүлж баталснаас шалтгаалан 190.4 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна. Энэ нь аймгийн ИТХ-д гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын, Тосонцэнгэл сумын болон Улиастай Хот тохижилт үйлчилгээний албаны, аймгийн Ахмадын хороо, “Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв” ОНӨААН-ийн

төсөв нэмэгдсэнтэй холбоотой байна.

В.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт сайжирч байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2022-2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар хяналтыг хэрэгжүүлэн, 2022 онд 74 байгууллагын 21,132.2 сая төгрөгийн зөрчилд 68 зөвлөмж, 1,156.6 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлэн биелэлтийг тооцсон.

2023 онд 13 байгууллагын 1,882.6 сая төгрөгийн зөрчилд 10 зөвлөмж, 785.6 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 2024 онд 4 байгууллагын шилэн дансны цахим хуудаст мэдээлээгүй зөрчилд 3 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлэн биелэлтийг тооцож ажилласан.

Хүснэгт 10. Хуулийн 20 дугаар зүйл 20.5 /сая төгрөгөөр/

Аудитын шийдвэрлэлт	2022 онд		2023 онд		2024 онд	
	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн
Зөвлөмж	68	21,132.2	10	1,882.6	3	0
Албан шаардлага	6	1,156.6	3	785.6	1	0
Нийт зөрчил	74	22,288.9	13	2,668.2	4	0

Эх сурвалж: Fas program-Шийдвэрийн дэлгэрэнгүй бүртгэл.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Авто тээврийн хэрэгсэл ашиглахыг хориглосон 28 байгууллагад 33 автомашин бүртгэлтэй байна. Мөн 126 төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй байна.
2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно” гэж заасныг аймаг, сумдын ИТХ нь хэрэгжүүлээгүй байна.
3. Тэтгэвэрт гарсан албан хаагчид тэтгэмж давхардуулан олгодог зөрчлийг давтан гаргасаар байна.
4. Ургамал сумын Засаг дарга нь тус сумын Эрүүл мэндийн төвийн орон тоог 2025 онд 2 их эмчээр нэмэгдүүлсэн нь Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын 2015 оны 498/315 дугаартай хамтарсан тушаалаар батлагдсан “Сум тосгоны эрүүл мэндийн төвийн орон тооны норматив”-ыг зөрчсөн байна.
5. 10 төсөвт байгууллагын удирдлага нь ажилтнуудад хууль журамд тусгагдаагүй 11.2 сая төгрөгийн тэтгэмж олгосон.
6. 2024 оны эцсийн байдлаар зарим төсөвт байгууллагуудын эм, хүнсний материалын хугацаа дууссан, шатахуун, эм, хүнсний материалыг шаардлагатай хэмжээнээс илүү нөөцөлсөн зөрчил илэрлээ.
7. Аймагт үйл ажиллагаагаа явуулдаг 7 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтыг хэрэгжүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулаагүй байна.
8. Аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон төсөл арга хэмжээг тусгаж баталсан байна.
9. Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй байхад гэрээ байгуулах шийдвэрүүдийг гаргасан байна.
10. Аймгийн ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг ИТХ-аас батлахдаа иргэдээс санал аваагүй, урьдчилсан жагсаалтад тусгагдаагүй төсөл арга хэмжээг баталж байна.
11. Цахим системээс худалдан авалт хийж байгаа байгууллагын тоо шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгаа нь цахим дэлгүүрт байршсан бараа бүтээгдэхүүн нь зах зээл дээрх бараа бүтээгдэхүүний бодит үнээс үнэтэй, худалдан авагчийн тавьсан шаардлагад нийцэхгүй байгаатай холбоотой байна.
12. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал зардлын хэмнэлт нь төсвийг өмнөх оноос нэмэгдүүлэн баталсантай холбоотойгоор үүссэн байна.
13. Алдархаан, Дөрвөлжин, Отгон, Сонгино, Тэс, Улиастай сумдын ЗДТГ төсвөөс хүндэтгэлийн арга хэмжээ, баяр ёслол, уралдаан тэмцээнд 85.9 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ.
14. 2024 онд халаах эзлэхүүний үнэ тарифыг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор халаалтын зардлын гүйцэтгэлийг өмнөх оноос 2,069.8 сая төгрөгөөр

нэмэгдүүлсэн боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д “нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах” гэж заасныг хэрэгжүүлээгүй, дулаан үйлдвэрлэгч компаниудад утаа шүүх шүүлтүүртэй болох, энгийн халаалттай хувийн сууцтай иргэдийг нэгдсэн халаалтад холбох үүргүүдийг хүргүүлээгүй байна.

15. Улиастай сумын 3, 8 дугаар цэцэрлэгийн, Сантмаргац сумын сургууль, цэцэрлэгийн, Тосонцэнгэл сумын 2 дугаар сургууль, 4 дүгээр цэцэрлэгийн, Нөмрөг сумын сургуулийн нягтлан бодогч нар өрийн мэдээллийг 104.5 сая төгрөгөөр буруу мэдээлсэн, аймгийн Эрүүл мэндийн газрын төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн 3 эмнэлгийн тогтмол зардлын төсвийг 289.7 сая төгрөгөөр илүү тооцоолсон байна.
16. 2024 онд Их-Уул сумын ИТХ, Нөмрөг, Тосонцэнгэл сумдын ЗДТГ нь батлагдсан орон тооноос 4 орон тоо дутуу ажилласны цалингийн хэмнэлтээс 20.0 сая төгрөгийг байгууллагын ажиллагсдын урамшуулал, бусад зардалд зарцуулсан байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

АЙМАГ, СУМДЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно” гэж заасныг хэрэгжүүлэх

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Г.ӨНӨРБАЯР-т

1. Авто тээврийн хэрэгсэл ашиглахыг хориглосон байгууллагуудад жолоочийн орон тоог цомхотгох, өөр албан тушаалд сэлгүүлэн ажиллуулах шийдвэрийн аль нэгийг гаргах чиглэл хүргүүлэн биелэлтийг тооцох
2. 126 төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй авто тээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаартай болгох
3. Тэтгэвэрт гарсан албан хаагчид тэтгэмж давхардуулан олгодог, төрийн албан хаагчдад хууль журамд тусгагдаагүй тэтгэмж олгодог, цалингийн зардлаас урамшуулал олгодог, нэмэлт санхүүжилтийн орлогоос шатахууны нөөцөлдөг зөрчлүүдийг таслан зогсоох
4. Аймагт үйл ажиллагаагаа явуулдаг 6 орон нутгийн өмчит хуулийн этгээдэд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах чиглэл хүргүүлэн биелэлтийг тооцох
5. 2025 оны төсвийг тодотгон батлахдаа бараа үйлчилгээний бусад зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг өмнөх оноос нэмэгдүүлэхгүй байх, бараа үйлчилгээний зардлыг үрэлгэн, хууль зөрчин зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох
6. Дулаан үйлдвэрлэгч компаниудад уурын зуухнуудыг утаа шүүх шүүлтүүртэй болгох, энгийн халаалттай хувийн сууцтай иргэдийг нэгдсэн халаалтад холбох үүргүүдийг хүргүүлэх, тусгай шилжүүлгийн болон орон нутгийн төсөвт байгууллагуудад халаалтын чанарын доголдлыг тухай бүр бүртгэн баримтжуулж, халаалтын зардлын гүйцэтгэлээс хасаж тооцох үүргийг хүргүүлэн хэрэгжүүлэх

УРГАМАЛ ЗАСАГ ДАРГА Г.ГЭРЭЛТ-ОД-д

1. Эрүүл мэндийн төвийн орон тоог 2025 онд 2 их эмчээр нэмэгдүүлэн Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын 2015 оны 498/315 дугаартай хамтарсан тушаалаар батлагдсан “Сум тосгоны эрүүл мэндийн төвийн орон тооны норматив”-ыг зөрчсөн зөрчлийг арилгах

Отгон, Дөрвөлжин, Баянтэс сумдын засаг дарга нарт:

1. Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй тохиолдолд гэрээ байгуулахгүй байх

АЙМГИЙН БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗАРТ:

1. Хавсралтад заагдсан байгууллагууд хүнсний материалын үлдэгдлийн хугацаа дууссан байхад дотоод хяналтаар илрүүлэн зарлагадаагүй, хүнсний материалын үлдэгдлийг шаардлагатай хэмжээнээс илүү нөөцөлсөн, зах зээлийн үнээс илүү үнээр бэлтгэсэн зөрчлийг арилгах, цаашид энэ зөрчлийг таслан зогсоохын тулд дотоод хяналтыг хэрэгжүүлэх
2. Авто тээврийн хэрэгсэл ашиглахыг хориглосон байгууллагуудад жолоочийн орон тоог цомхотгох, өөр албан тушаалд сэлгүүлэн ажиллуулах шийдвэрийн аль нэгийг гаргах чиглэл хүргүүлэн биелэлтийг тооцох
3. Улиастай сумын 3, 8 дугаар цэцэрлэгийн, Сантмаргац сумын сургууль, цэцэрлэгийн, Тосонцэнгэл сумын 2 дугаар сургууль, 4 дүгээр цэцэрлэгийн, Нөмрөг сумын сургуулийн нягтлан бодогч нарын өрийн мэдээллийг 104.5 сая төгрөгөөр буруу мэдээлсэн зөрчлийг арилгах, цаашид энэ зөрчлийг таслан зогсоохын тулд дотоод хяналтыг хэрэгжүүлэх

АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ:

1. Хавсралтад заагдсан байгууллагууд эм, эмнэлгийн хэрэгслийн үлдэгдлийн хугацаа дууссан байхад дотоод хяналтаар илрүүлэн зарлагадаагүй, эмийн үлдэгдлийг шаардлагатай хэмжээнээс илүү нөөцөлсөн зөрчлийг арилгах
2. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмийн үлдэгдэл E-Health программын үлдэгдлээс 127.9 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа зөрчлийг арилгах үүргийг аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргад өгч, биелэлтийг тооцох
3. Хавсралтад заагдсан байгууллагуудын төрийн албан хаагчдад хууль журамд тусгагдаагүй тэтгэмж олгодог зөрчлийг таслан зогсоох
4. Аймгийн Эрүүл мэндийн газрын төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн 3 эмнэлгийн тогтмол зардлын төсвийг 289.7 сая төгрөгөөр илүү тооцоолсон зөрчлийг арилгах, цаашид энэ зөрчлийг таслан зогсоохын тулд дотоод хяналтыг хэрэгжүүлэх

Үндэсний аудитын газрын нэгтгэсэн аудитын тайланд тусгуулах санал:

1. Автомашин ашиглахыг хориглосон байгууллагууд дуудлагаар автомашины үйлчилгээ авах төрийн болон орон нутгийн өмчит автотээврийн байгууллага байхгүйгээс хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй өндөр үнээр түрээсийн гэрээ байгуулдаг, албан томилолтоор хөдөө орон нутагт ажиллах үеийн аюулгүй байдалд эрсдэл учрах нөхцөл байдал үүсэхээр байна. Иймд хуулийн 6.3 дахь заалтыг хүчингүй болгуулах арга хэмжээ авах саналтай байна.
2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д “байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэхийг хориглоно” гэж заасныг хүчингүй болгуулах саналтай байна. Учир нь төрийн байгууллагууд хийсэн ажлын тайлан, үр дүн, үйл ажиллагааны цар хүрээгээ цахим сүлжээ ашиглан контент, нэвтрүүлэг хэлбэрээр түгээхгүй байх нь төрийн үйлчилгээний хүртээмж, үр дүнд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.
3. Төрийн албан хаагчид олгох тусламж, дэмжлэг, тэтгэмжийг Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1-д тусган, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр”-ийг журамласан боловч төрийн албан хаагч шинээр гэр бүл болох, гэр бүлийн хүн нь нас барах, шинээр хүүхэдтэй болох зэрэгт үзүүлэх тусламж дэмжлэг нь журамлагдаагүй, зөвхөн байгууллагын дотоод журмаар зохицуулагдаж байгаад анхаарч, холбогдох байгууллагад уламжлах
4. Цахим дэлгүүрт байршсан бараа, бүтээгдэхүүний нэр төрөлд хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн баяжилт хийх, зах зээл дээрх бараа, бүтээгдэхүүний үнэтэй харьцуулах замаар үнэд өөрчлөлт оруулах саналыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт уламжлах.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ


МОНГОЛ УЛС
ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
81090 Улаанхот, Завхан аймаг
Утас: 7575-1155, Факс: 7046-2550
И-мэйл: za@zavkhan.gov.mn

2025. 05. 12 № 2/465
танай _____ -ны № _____ Т

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

“Төрийн хэмнэлтийн тухай хуулийн
хэрэгжилт, үр дүн” сэдэвт нийцлийн аудитын
тайлангийн төсөлтэй танилцлаа.
Төсөлтэй холбоотой саналгүй болно.

ОРЛОГЧ  Д.УУЖИМСАНАА

81-300194



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 11/9

Улиастай

Аудитын тайлан баталгаажуулах тухай


Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, 18.10 дахь хэсэг, 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлан"-г нэгдүгээр хавсралтаар, аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг аймгийн Засаг дарга Г.Өнөрбаярт хүргүүлэхийг ахлах аудитор (Г.Заяа)-д, нээлттэй аудит сайтад байршуулахыг аудитор (Г.Нармандах)-д даалгасугай.

3. Аудитаар хүргүүлсэн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга Г.Өнөрбаярт зөвлөсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Х.Болдбаатар)-т үүрэг болгосугай.


Д.БАТ-УНДРАА

D/Албан бичиг/Тушаал-А/2025